




МОНГОЛ УЛСАД ИААН-ИЙН ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ САЙЖРУУЛЖ, ХУРДАСГАХ НЬ

Итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж (ИААН)-
ийн хөтөлбөр сэдэвт танхимын сургалт

**ХЭСЭГ 10: Цахимжуулалт болон ИААН-
ийн хөтөлбөрөөр дамжуулан ногоон
гааль болох нь танилцуулга**

Деннис Капистрано Пантасико

2024 оны дөрөвдүгээр сарын 29-30





Оршил

Ногоон гаалийн санаачилга

- Хэрэв нөөцийг зөв төвлөрүүлэхгүй бол хил дамнасан хууль бус худалдаатай тэмцэхэд гаалийн болон бусад хилийн хяналтын ажилтнуудыг сургахад цаг хугацаа их шаарддаг, өндөр өртөгтэй байгаагийн хариуд Ногоон гаалийн санаачилга (НГС) гарч ирсэн,
- Гааль, хилийн хяналтын байгууллагуудыг өдөр тутмын ажлынхаа явцад олон улсын гэрээ хэлэлцээрийн чухал асуудлуудыг хэрэгжүүлэх замаар байгаль орчныг хамгаалах хамтын хүчин чармайлтад дэмжлэг үзүүлнэ.

Гаалийн байгууллага, ТТА-ын чухал үүрэг

- Энэхүү санаачилга нь гааль болон түнш төрийн агентлагуудыг холбогдох хууль эрх зүйн хэрэгслийн талаар хэрэгтэй мэдээлэл, зааварчилгаагаар хангах, ингэснээр байгаль орчинд ээлтэй барааны хууль ёсны худалдааг хөнгөвчлөхийн зэрэгцээ эдгээр барааны хууль бус худалдаанаас урьдчилан сэргийлэх зорилготой юм.
- Байгаль орчинд мэдрэмтгий барааны худалдаа нь олон хэлбэртэй байж болох бөгөөд гааль болон ТТА-ууд холбогдох бараа бүтээгдэхүүнийг таньж, хууль бус, хяналтгүй худалдааны үр дагаврыг ойлгох чадвартай байх нь маш чухал юм.



Зорилтууд



Үндэсний хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, Ногоон гаалийн санаачилгын хүрээнд гэрээ хэлэлцээрийг давхар харгалзахад гаалийн болон ТТА-уудын ажилтнуудад туслах.



ИААН хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр цахимжуулах замаар Байгаль орчны үндсэн хэлэлцээрүүд (БОҮХ) үндэсний хэмжээнд дагаж мөрдөхийг дэмжих.



Худалдаатай холбоотой заалтууд, худалдааг хэрхэн зохицуулдаг, гаалийн болон хилийн бусад байгууллагуудын үүрэг, хариуцлага, БОҮХ-тэй холбоотой тусгай нэр томъёо, холбогдох заалтуудын ерөнхий тоймыг өгөх.



БОҮХ-ийн мониторингийн шаардлагыг хэрэгжүүлэх практик талуудыг судлах, үүнд: сэжигтэй зүйлийг илрүүлэх, шалгах; хураан авах, устгах; эрүүл мэнд, аюулгүй байдал; бусад хууль эрх зүйн асуудал; болон бусад эрх бүхий байгууллагатай хамтран ажиллах



Байгаль орчны үндсэн хэлэлцээрүүд



Аюултай хог хаягдлын хил дамнасан тээвэрлэлт, түүнийг устгалд оруулах хяналтын тухай Базелийн конвенц



Биологийн олон янз байдлын тухай конвенцийн биоаюулгүй байдлын тухай Картахена протокол (CBD)



Ховордсон зэрлэг амьтан, ургамлын төрөл зүйлийн олон улсын худалдааны тухай конвенц (CITES)



Олон улсын худалдаанд зарим аюултай химийн бодис, пестицидийг урьдчилан мэдээлэлжүүлсэн зөвшөөрлийн журмын тухай Роттердамын конвенц




Тогтвортой органик бохирдуулагчийн тухай Стокгольмын конвенц



ISO 9001, 14001, 27000, 28000 болон ISPS гэрчилгээ



shutterstock.com · 1428961169





Ногоон гаалийн цахимжуулалт

ИААН хөтөлбөр

E-BaseI – Аюултай болон хуванцар хог хаягдлын хил дамнасан үр ашигтай тээвэрлэлтийг дэмжих

Итгэмжлэгдсэн түншлэл

ИААН нь урьдчилан зөвшөөрөл авсан байгууламжуудаар дамжуулан одоо байгаа худалдааны хяналтыг нэмэлтээр дэмжиж чадна

Цаасгүй худалдаа – эх үүсвэр дээр нь мэдэгдэх, импортлогч улсад хүлээн авч, бүрдүүлснийг баталгаажуулах

Нэг цонхны платформ

Нэг цонхны платформыг ашигласнаар хилийн журмыг цаасгүй, ил тод болгож, зохицуулалтын хяналтыг оновчтой болгох боломжтой.

Цахим мэдээлэл солилцох нь нэн чухал юм

- Харилцан ажиллах чадвар
- Синхрончлогдсон
- Баримт бичгийн менежмент

Одоо байгаа олон улсын санаачилга

- Хог хаягдлыг тээвэрлэх тухай мэдэгдэл
- Байгаль орчны хүрээ

Эрсдэлийн зорилт болон профайл тодорхойлох стандартууд

Хууль бус хогны худалдааг илүү сайн илрүүлж, тэмцэхийн тулд хууль сахиулах, тандалтын мэдээлэл солилцох, хил дамнасан хамтын ажиллагааг сайжруулах

Гааль болон ТТА-ын хангалттай хүчин чадал, байгаль орчинд ээлтэй менежментийг харуулахад тусалж чадна



Гаальд нөлөөлдөг ногоон NTM




Эм, эрүүл мэндийн бүтээгдэхүүний хүртээмжийг сайжруулахын зэрэгцээ тэдгээрийн аюулгүй байдал, урьдчилан таамаглах боломжтой үр дүнтэй байдлыг хангах



Хүний эрүүл мэндэд хортой (хар тамхи, мансууруулах бодис гэх мэт) бүтээгдэхүүний хэрэглээг бууруулах




Хүнсний аюулгүй байдал



Эрүүл хүнсний хэрэглээг нэмэгдүүлэхийн зэрэгцээ халдварт бус өвчин (хүнсний чанар, шошго) үүсэхэд нөлөөлж болзошгүй хүнсний бүтээгдэхүүн, нэмэлтүүдийн хэрэглээг багасгах;



Зам дээр осол гэмтэл, нас баралтыг бууруулах (жишээлбэл, тээврийн хэрэгслийн аюулгүй байдал);



Аюулгүй амьдрах орчныг бүрдүүлэх, хортой бодис (жишээ нь, химийн хорт бодис) -ын өртөх байдлыг бууруулах



Логистикийн ногоон шийдэл



Нийлүүлэгчийг сонгохдоо тогтвортой байдлын асуудлыг тусгаснаар байгальд ээлтэй туршлагатай, ёс зүйтэй эх үүсвэрийн бодлого бүхий түншүүдийг сонгох боломжтой.



Эрэлтийг урьдчилан таамаглах хэрэгсэл, хамтын төлөвлөлтийг хэрэгжүүлэх нь үр ашиггүй байдлыг бууруулж, бараа материалын түвшинг оновчтой болгож, хог хаягдлыг бууруулж, нөөцийн ашиглалтыг сайжруулахад хүргэдэг.



Дахин боловсруулах эсвэл био задралд ордог материалыг ашиглах, сав баглаа боодлын дизайныг оновчтой болгох нь тээвэрлэлтийн байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг мэдэгдэхүйц бууруулж чадна.




Бизнесүүд флотын менежментийг оновчтой болгох, түлшний зарцуулалтыг хянах, сайжруулах шаардлагатай газруудыг тодорхойлохын тулд бодит цагийн өгөгдлийн аналитик болон хяналтын системийг ашиглах боломжтой.



Компаниуд цахилгаан болон холимог ачааны машин зэрэг эрчим хүчний хэмнэлттэй машин, тоног төхөөрөмжид хөрөнгө оруулалт хийж, жолооч бэлтгэх хөтөлбөр, тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээгээр дамжуулан түлшний зарцуулалтыг оновчтой болгох боломжтой.




Сорилтуудыг шийдвэрлэх



Ил тод байдал

- Дүрэм, шаардлагын ил тод тогтолцоог бий болгох
- Эрсдэлийг тодорхойлох, үр дүнтэй хяналтын тогтолцоог хэрэгжүүлэх
- Холбогдох төрийн байгууллагууд болон худалдааны салбарынханд сурталчилгаа, сургалт явуулах



Хялбарчлал ба стандартчилал

- Худалдааны түншүүдийн хооронд цахимжуулах замаар гаалийн худалдааны журмыг хялбарчлах
- Худалдаачдад зориулсан онооны системээр дамжуулан худалдааны журмыг хялбарчлах эрсдэлийн профайлыг тохиролцох
- Олон улсын стандартыг ашиглах, цаашид холбогдох стандартуудыг боловсруулах



Нийлүүлэлтийн сүлжээг хянах чадвар

- Сонголтод нөлөөлж буй системийн зан байдлыг багтаасан бүтээгдэхүүний мөншөглтийг хянах, үнэлэх
- Мөшгих системийг Нэг цонхны платформтой нэгтгэх
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албатай нягт уялдаатай ажиллана



Баярлалаа

